



- ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН -

Аудитын нэр: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн
2025 оны 1 дүгээр улирлын тайлан

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

1. Танилцуулга

Нийгмийн даатгалын ерөнхий газар, харьяа 31 байгууллага нь байгууллагын цахим хуудсанд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дахь хэсэгт заасан 34 төрлийн 66 нээлттэй мэдээллийг байршуулах үүрэгтэй.

Нээлттэй мэдээллийг Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”, Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж хэрэгжүүлэн ажиллаж байгаа эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэв.

2. Зорилго

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нээлттэй мэдээллийг олон нийтэд ил тод болгох, бүрэн байршуулах, илэрсэн алдаа дутагдлыг арилгах, дүгнэлт, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангаж олон нийтэд Нийгмийн даатгалын байгууллагын мэдээллийг ил тод, нээлттэй байлгахад гол зорилго оршино.

3. Хамрах хүрээ, хугацаа

2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацааны Нийгмийн даатгалын ерөнхий газар болон төв, орон нутгийн байгууллагуудын цахим хуудсанд мэдээлэл байршуулж нийтэлсэн байдлыг хамруулав.

4. Арга аргачлал

Хяналт-шинжилгээ, үнэлгээг байгууллагын цахим хуудсанд байршуулсан ажлын байрны болон албан хаагчдын мэдээлэл, ёс зүйн дүрэм, журам, шилэн дансны мэдээлэл, үйлчилгээний мэдээлэл, батлагдсан төсөв, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, сарын мэдээ болон холбогдох бусад мэдээ мэдээлэлд үндэслэн хийж гүйцэтгэлээ.

Хяналт шинжилгээ, үнэлгээг дараах чиглэлийн дагуу гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Хуулийн 8.2 дахь хэсэгт заасан чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийг бүрэн байршуулсан эсэх;
- Хуулийн 8.3 дахь хэсэгт заасан мэдээлэл хариуцагч өөрийн хүний нөөцийн талаарх мэдээллийг бүрэн байршуулсан эсэх;
- Хуулийн 8.4 дэх хэсэгт заасан мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг бүрэн байршуулсан эсэх;
- Хуулийн 8.5 дахь хэсэгт заасан мэдээлэл хариуцагч хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний талаар мэдээллийг бүрэн байршуулсан эсэх;
- Хуулийн 8.6 дахь хэсэгт заасан бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангасан эсэх

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хэрэгжүүлэхэд дараах хууль эрх зүйн баримт бичгийг эх үүсвэр болгон ашиглалаа. Үүнд:

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”;
- Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”;
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны А/40 дүгээр тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын вебсайт ажиллуулах журам”;
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын заавар, зөвлөмж;

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

5. Үр дүн

5.1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дахь хэсэгт заасан 34 төрлийн мэдээллийг байршуулсан байдал:

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5 заалтын 34 мэдээллийг мэдээлж байршуулсан байдлыг хүснэгтээр харуулбал. Үүнд:

- Хуулийн 8.2 дахь хэсэгт заасан чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх 15 мэдээлэл;
- Хуулийн 8.3 дахь хэсэгт заасан мэдээлэл хариуцагч өөрийн хүний нөөцийн талаарх 5 мэдээлэл;
- Хуулийн 8.4 дэх хэсэгт заасан мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх 10 мэдээлэл;
- Хуулийн 8.5 дахь хэсэгт заасан мэдээлэл хариуцагч хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний талаар 3 мэдээлэл;
- Хуулийн 8.6 дахь хэсэгт заасан бусад 1 мэдээлэл;

№	Газар	Мэдээлэл байршуулсан байдал					Хэрэгжилтийн хувь
		8.2 Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	8.3.Мэдээлэл хариуцагч өөрийн хүний нөөцийн талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:	8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байдал:	8.5.Мэдээлэл хариуцагч хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байдал:	8.6 Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	
1	Архангай	81.77%	66.07%	64.58%	60.00%	61.11%	66.71%
2	Баян-Өлгий	83.94%	77.78%	88.54%	98.61%	90.48%	87.87%
3	Баянхонгор	90.51%	80.36%	95.45%	70.83%	100.00%	87.43%
4	Булган	96.09%	100.00%	100.00%	83.33%	100.00%	95.88%
5	Говь-Алтай	92.19%	95.36%	90.31%	99.44%	78.33%	91.13%
6	Говьсүмбэр	94.72%	84.17%	86.67%	91.67%	83.33%	88.11%
7	Дархан-Уул	92.13%	86.90%	100.00%	94.44%	91.67%	93.03%
8	Дорноговь	100.00%	100.00%	91.67%	100.00%	95.83%	97.50%
9	Дорнод	94.72%	92.86%	97.92%	90.00%	100.00%	95.10%
10	Дундговь	94.21%	97.02%	90.00%	81.94%	75.00%	87.63%
11	Завхан	87.76%	73.89%	86.42%	87.50%	83.33%	83.78%
12	Орхон	100.00%	96.43%	96.97%	100.00%	88.54%	96.39%
13	Өвөрхангай	81.51%	69.05%	83.33%	83.33%	83.33%	80.11%
14	Өмнөговь	55.09%	52.98%	72.50%	66.67%	68.75%	63.20%
15	Сүхбаатар	97.22%	83.93%	97.22%	100.00%	96.30%	94.93%
16	Сэлэнгэ	60.39%	36.31%	47.92%	56.94%	87.50%	57.61%
17	Төв	0.00%	0.00%	0.00%	0.00%	0.00%	0.00%
18	Увс	0.00%	0.00%	0.00%	0.00%	0.00%	0.00%
19	Ховд	88.97%	95.24%	93.59%	100.00%	85.71%	92.70%
20	Хөвсгөл	62.96%	62.50%	79.86%	62.50%	60.42%	65.65%
21	Хэнтий	95.52%	100.00%	87.50%	100.00%	91.67%	94.94%
Аймгийн дүн		78.56%	73.85%	78.59%	77.49%	77.20%	77.14%
22	Багануур	70.31%	83.33%	83.33%	73.61%	41.67%	70.45%

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

23	Багахангай	0.00%	0.00%	0.00%	0.00%	0.00%	0.00%
24	Баянгол	47.30%	50.00%	27.50%	45.83%	15.28%	37.18%
25	Баянзүрх	76.30%	82.74%	92.50%	83.33%	100.00%	86.97%
26	Налайх	86.67%	100.00%	77.78%	83.33%	50.00%	79.56%
27	Сонгинохайрхан	61.72%	50.00%	86.67%	75.00%	87.50%	72.18%
28	Сүхбаатар	61.72%	75.00%	69.17%	75.00%	75.00%	71.18%
29	Хан-Уул	66.15%	75.00%	100.00%	63.89%	27.08%	66.42%
30	Чингэлтэй	81.94%	81.55%	83.33%	83.33%	55.56%	77.14%
Дүүргийн дүн		61.35%	66.40%	68.92%	64.81%	50.23%	62.34%
31	НДЕГ	97.66%	90.48%	94.05%	88.89%	89.58%	92.13%
Нийт		79.19%	76.91%	80.52%	77.06%	72.34%	77.20%

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу 5 төрлийн 34 мэдээллийг мэдээлж байршуулсан. Үүнд:

- Хуулийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийг
 - Аймаг: 78.56 хувь;
 - Дүүрэг: 61.35 хувь;
 - Салбарын хэмжээнд: 79.19 хувьтай;
- Хуулийн 8.3 дахь хэсэгт заасны дагуу мэдээлэл хариуцагч өөрийн хүний нөөцийн талаарх мэдээллийг
 - Аймаг: 73.85 хувь;
 - Дүүрэг: 66.40 хувь;
 - Салбарын хэмжээнд: 76.91 хувьтай;
- Хуулийн 8.4 дэх хэсэгт заасны дагуу мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг
 - Аймаг: 78.59 хувь;
 - Дүүрэг: 64.81 хувь;
 - Салбарын хэмжээнд: 80.52 хувьтай;
- Хуулийн 8.5 дахь хэсэгт заасны дагуу мэдээлэл хариуцагч хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний талаар мэдээллийг
 - Аймаг: 77.49 хувь;
 - Дүүрэг: 68.92 хувь;
 - Салбарын хэмжээнд: 77.06 хувьтай;
- Хуулийн 8.6 дахь хэсэгт заасны дагуу бусад мэдээллийг
 - Аймаг: 77.20 хувь;
 - Дүүрэг: 50.23 хувь;
 - Салбарын хэмжээнд: 72.34 хувьтай байна.

5.2. Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний талаар:

Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-д заасан аргачлалын дагуу мэдээллийг дараах шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэллээ. Үүнд:

- Мэдээллийн хүртээмжтэй байдал;
- Хугацаандаа нийтэлсэн байдал;
- Мэдээллийн бүрэн бүтэн байдал;
- Эх сурвалжийн байдал;

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ 4 ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР

№	Газар	Шалгуур үзүүлэлт				Хэрэгжилтийн хувь
		Мэдээллийн хүртээмжтэй байдал	Хугацаандаа нийтлэгдсэн байдал	Мэдээллийн бүрэн бүтэн байдал	Эх сурвалжийн тодорхой байдал	
1	Архангай	81.81%	100.00%	65.15%	33.33%	70.07%
2	Баян-Өлгий	79.92%	91.30%	73.91%	100.00%	86.28%
3	Баянхонгор	68.75%	92.50%	77.50%	92.50%	82.81%
4	Булган	93.58%	100.00%	93.16%	98.29%	96.26%
5	Говь-Алтай	77.69%	97.43%	97.43%	92.30%	91.21%
6	Говьсүмбэр	96.07%	96.07%	90.19%	90.19%	93.13%
7	Дархан-Уул	78.57%	100.00%	100.00%	95.23%	93.45%
8	Дорноговь	100.00%	100.00%	100.00%	89.14%	97.29%
9	Дорнод	85.89%	100.00%	93.16%	100.00%	94.76%
10	Дундговь	91.88%	97.43%	94.01%	85.47%	92.20%
11	Завхан	56.82%	95.12%	86.50%	98.37%	84.20%
12	Орхон	97.03%	100.00%	92.59%	97.03%	96.66%
13	Өвөрхангай	94.96%	97.67%	35.65%	93.02%	80.33%
14	Өмнөговь	70.23%	92.85%	32.53%	48.41%	61.01%
15	Сүхбаатар	91.08%	100.00%	89.14%	100.00%	95.06%
16	Сэлэнгэ	42.25%	74.16%	55.83%	39.16%	52.85%
17	Төв	0.00%	0.00%	0.00%	0.00%	0.00%
18	Увс	0.00%	0.00%	0.00%	0.00%	0.00%
19	Ховд	97.51%	97.87%	97.87%	72.34%	91.40%
20	Хөвсгөл	83.00%	100.00%	33.33%	58.66%	68.75%
21	Хэнтий	99.52%	100.00%	96.82%	80.95%	94.32%
Аймгийн дүн		75.55%	87.26%	71.66%	74.49%	77.24%
22	Багануур	87.28%	94.73%	84.21%	33.33%	74.89%
23	Багахангай	0.00%	0.00%	0.00%	0.00%	0.00%
24	Баянгол	19.58%	80.00%	35.00%	26.66%	40.31%
25	Баянзүрх	89.47%	97.36%	81.57%	65.78%	83.55%
26	Налайх	91.66%	91.66%	87.96%	67.59%	84.72%
27	Сонгинохайрхан	56.30%	91.89%	82.88%	45.04%	69.03%
28	Сүхбаатар	56.30%	97.29%	81.08%	45.04%	69.93%
29	Хан-Уул	78.50%	94.73%	75.43%	49.12%	74.45%
30	Чингэлтэй	95.61%	97.36%	93.85%	34.21%	80.26%
Дүүргийн дүн		63.86%	82.78%	69.11%	40.75%	64.12%
31	НДЕГ	97.61%	100.00%	100.00%	79.36%	94.24%
Нийт		79.0%	90.0%	80.3%	64.9%	78.5%

Дээрх хүснэгтээс үзэхэд Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд:

- **Мэдээллийн хүртээмжтэй байдал** буюу мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбар болон мэдээллийн хэрэгсэл ашиглан олон нийтэд ил тод мэдээлсэн байдал 79 хувь;
- **Хугацаандаа нийтлэгдсэн байдал** буюу мэдээллийг хуульд заасан хугацаанд нь олон нийтэд хүргэсэн байдал 90 хувь;

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

- **Мэдээллийн бүрэн бүтэн байдал** буюу мэдээллийг бүрэн гүйцэд нийтэлсэн байдал 80.3 хувь;
- **Эх сурвалжийн тодорхой байдал** буюу мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах эрх бүхий албан тушаалтны мэдээллийг цахим хуудсанд байршуулсан байдал 64.9 хувьтай үнэлэгдсэн бөгөөд нийгмийн даатгалын байгууллага нь 1 дүгээр улиралын байдлаар 78.5 хувьтай байна.

6. Алдаа дутагдал:

Байгууллагын цахим хуудаст мэдээлсэн мэдээллээс үзэхэд мэдээллийг байршуулж мэдээлээгүй, хугацаа хоцроож мэдээлсэн, дутуу мэдээлсэн, мэдээллийг шинэчлээгүй, мэдээллийн эх сурвалж тодорхойгүй, мэдээллийн бүрэн бүтэн байдал хангалтгүй, хамааралгүй өөр мэдээлэл байршуулсан зэрэг нийтлэг алдаа дутагдал давтагдаж байгаа нь иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн ил тод, нээлттэй байх, мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа шуурхай, хялбар байх, мэдээлэл нь ойлгомжтой, үнэн зөв, бүрэн байх зарчмыг алдагдуулж байна.

Түүнчлэн хариуцсан албан хаагч шилжсэн, ажлаасаа чөлөөлөгдсөн, веб сайт ажиллахгүй, вирустсэн гэх шалтгаанаар ажил олгогч, иргэн, даатгуулагчид мэдээллийг хүргэхгүй байгаа нь хууль, дүрэм, журам, стандартыг мөрдөж ажиллаагүй, нээлттэй мэдээллийг ил тод байлгах шаардлагыг хангаагүй байна.

7. Дүгнэлт

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дахь хэсэгт заасан мэдээллийг байршуулж мэдээлсэн байдалд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр байгууллагын цахим хуудсанд мэдээлэл байршуулалт дүүргийн Нийгмийн даатгалын газрын хувьд 62.34 хувь /дундаж/-тай, аймгийн Нийгмийн даатгалын газрын хувьд 77.14 хувь /дундаж/-ийн гүйцэтгэлтэй байна.

Байгууллагын мэдээллийн ил тод байдлыг журамд заасан 4 шалгуур үзүүлэлтээр шинжилгээ, үнэлгээ хийхэд хуулийн хэрэгжилт дүүргийн Нийгмийн даатгалын газруудын хувьд 64.12 хувь /дундаж/-тай, аймгийн Нийгмийн даатгалын газруудын хувьд 77.24 хувь /дундаж/-ийн хэрэгжсэн байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дахь хэсэгт заасан мэдээллийг байршуулсан байдал салбарын хэмжээнд 77.2 хувь /дундаж/-ийн гүйцэтгэлтэй.

Мөн байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлыг журамд заасан 4 шалгуур үзүүлэлтээр дүгнэхэд Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 78.5 хувь /дундаж/-ийн хэрэгжилттэй байна.

Өмнөх оны жилийн эцсийн үнэлгээг мөн үетэй харьцуулахад дүүргийн хэмжээнд 5.1-д заасан мэдээлэл 16.92 хувиар, аймаг 2.12 хувиар, 5.2-т заасан мэдээлэл дүүрэг 16.35 хувиар, аймаг 6.42 хувиар буурсан байгаа нь ажил **“САЙЖРУУЛАХ”** шаардлагатай гэж дүгнэлээ.

8. Санал, зөвлөмж

1. Нийгмийн даатгалын ерөнхий газраас өгсөн заавар, журамтай нэг бүрчлэн танилцаж, хэрэгжилтийг хангаж ажиллах;
2. Нээлттэй байршуулсан мэдээллийг улирал бүр шинэчилж, мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдалд хяналт тавих;
3. Нээлттэй мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй, мэдээлээгүй газар болон албан хаагч нарт зөвлөмж хүргүүлэн, хариуцлага тооцож ажиллах;
4. Албан хаагч нарт сургалт зохион байгуулж, санал солилцох;
5. Нийгмийн даатгалын салбарын цахим хуудсыг Мэдээллийн технологийн төвтэй хамтарч шинэчлэх, засварлах, хөгжүүлэх ажлыг зохион байгуулах.

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хянасан:

Дотоод аудит, мониторингийн
газрын дарга

Б.Ганхуяг

Тайлан бичсэн:

Дотоод аудит, мониторингийн
газрын мэргэжилтэн

Э.Цолмон

--oOo--